



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх, зарим хязгаарлалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.6 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Хот хоорондын зорчигч тээвэр, суудлын галт тэрэг болон орон нутгийн хуваарьт нислэг, хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 06:00 цагаас нээж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах болон зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал С.Баатаржав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Улаанбаатар-Эрхүү-Улаанбаатар, Улаанбаатар-Улаан-Үд-Улаанбаатар чиглэлийн олон улсын хуваарьт нислэгийг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс 11-ний өдрийг дуустал хугацаанд түр зогсоох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай.

3. БН Солонгос Улс, Япон Улс, БН Итали Улс, Лалын БН Иран Улсаас ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин эх орондоо зорчиж буй Монгол Улсын иргэдийг 2020 оны 3 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зөвхөн агаарын замын “Буянт-Ухаа”, авто замын “Алтанбулаг-Хиагт”, төмөр замын “Сүхбаатар-Наушки” боомтоор улсын хил нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал

Ж.Бямбасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр, Монгол цэргийн өдөр, Наурызын баяр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болгож, энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Улсын онцгой комиссын “Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 2 дугаар тогтоолын 3 дахь заалтын “БНСУ, Япон, Итали” гэсний дараа “Иран” гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЦЭТГЭГЧ,
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН

A handwritten signature in black ink, corresponding to the name G. Ariunbujyan.